**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 09 сарын 25 өдөр Дугаар А/590 Арвайхээр

Ээлжит цэрэг татлага явуулах тухай

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны м/н 135 дугаар тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2019 оны н/93 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2019 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагын ажлыг 10 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 13-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. “Цэрэг татлага явуулах хуваарь”-ийг нэгдүгээр, “Эрүүл мэндийн үзлэг хийх эмч нарын комиссын бүрэлдэхүүн”-ийг хоёрдугаар, “Цэрэг татлагын үйл ажиллагаанд шаардагдах төсөв”-г гуравдугаар хавсралтаар тус тус батлалсугай.

3. Цэрэг татлагын товчооны дарга (Ц.Ганболд )-д ДААЛГАХ нь:

а. Цэрэг татлагын ажлыг Цэргийн штабын даргаар ахлуулж батлагдсан хуваарийн дагуу тухайн сумдад зохион байгуулан ажиллуулах.

б. Цэрэг татлагын товчооны бүрэлдэхүүнийг үүрэгжүүлж, цэрэг татлагын үед сахилга, дэг журам, техникийн бүрэн бүтэн байдлыг хангуулах бүх талын арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

4. Эрүүл мэндийн үзлэгээр явах эмч нарыг үүрэг даалгавраар хангаж, эмнэлгийн фургон УАЗ-452 авто машин /1 нэгж/-ийг 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 13-ны өдрийг хүртэлх хугацаанд гаргаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал (Э.Хүдэрчулуунд)-д даалгасугай.

5. Цэрэг татлагын үйл ажиллагаанд зарцуулах 3.711.760 (гурван сая долоон зуун арван нэгэн мянга долоон зуун жаран мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Г.ГАНБОЛД

011101085

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2019 оны ..09...
дугаар сарын ..25...ны өдрийн ..А/590.. дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

ЦЭРЭГ ТАТЛАГА ЯВУУЛАХ ХУВААРЬ

| Д/д | Сум | Он, сар, өдөр | Цаг | |
|---|---|---|---|---|
| | | | Эхлэх | Дуусах |
| 1. | Арвайхээр | 2019.10.01-02 | 08.30 | 18.00 |
| 2. | Баруунбаян-Улаан | 2019.10.04 | 08.30 | 18.00 |
| 3. | Нарийнтээл | 2019.10.05 | 08.30 | 18.00 |
| 4. | Хайрхандулаан | 2019.10.06 | 08.30 | 18.00 |
| 5. | Тарагт | 2019.10.07 | 08.30 | 18.00 |
| 6. | Уянга | 2019.10.08-09 | 08.30 | 18.00 |
| 7. | Бат-Өлзий | 2019.10.10 | 08.30 | 18.00 |
| 8. | Хужирт | 2019.10.11 | 08.30 | 18.00 |
| 9. | Зүүнбаян-Улаан | 2019.10.12 | 08.30 | 18.00 |

-oOo-

Аймгийн Засаг даргын 2019 оны ..09..
дугаар сарын ..28....ны өдрийн ..A/590..... дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

ЦЭРЭГ ТАТЛАГЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГ ХИЙХ ЭМЧ
НАРЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

| № | Эмч нарын хуваарь | Эмч нарын нэр |
|---|---|---|
| 1. | Ерөнхий эмч | Д.Мөнхнасан |
| 2. | Нүдний эмч | Г.Бямбасүрэн |
| 3. | Чих, хамар, хоолойн эмч | Ц.Лувсандамдин |
| 4. | Мэдрэлийн эмч | Л.Оюунчимэг |
| 5. | Сүрьеэгийн эмч | Б.Даваамаа |
| 6. | Дотрын эмч | С.Доржхорлоо |
| 7. | Мэс заслын эмч | Д.Батцэнгэл |
| 8. | Арьс өнгөний эмч | О.Чулуундолгор |

-oOo-

Аймгийн Засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/590 дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

## 2019 ОНЫ ХОЁРДУГААР ЭЭЛЖИЙН ЦЭРЭГ ТАТЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ ТӨСВИЙН ТООЦОО.

### 1. Шатах тослох материалын тооцоо

| д/д | Зориулалт | Машин | | | Шаардагдах ШТМ | | Нэгжийн үнэ | | Бүгд үнэ | | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | марк | тоо | явах км | А-92 /л/ | Масло /л/ | А-92 /л/ | Масло /л/ | А-92 /л/ | Масло /л/ | |
| 1 | 10 сумдаар тойрч цэрэг татлага явуулах | Ланд-105 | 1 | 900 | 198 | 1 | 1840 | 10000 | 364.320 | 10000 | 374.320 |
| | | Фургон машин | 1 | 900 | 180 | 1 | 1840 | 10000 | 331.200 | 10000 | 341.200 |
| 2 | Цэрэг татлагын товчоонд шаардагдах | ланд-105 | 1 | 200 | 44 | - | 1840 | - | 80.960 | - | 80.960 |
| 3 | Аймгаас УБ-т цэрэг хүргэх буцах | ланд-105 | 1 | 1100 | 242 | 1 | 1840 | 10000 | 445.280 | 10000 | 455.280 |
| **Дүн** | | | **2** | **3100** | **664** | **3** | **1840** | **10000** | **1.221.760** | **30000** | **1.251.760** |

### 2. Томилолтын төсөв.

| д/д | Албан тушаал | Суманд | | | | Улаанбаатарт | | | | Нийт Томилолтын зардал |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хүний тоо | ажиллах хоног | нэг хоногийн томилолт | Томилолтын зардал | Хүний тоо | ажиллах хоног | нэг хоногийн томилолт | Томилолтын зардал | |
| 1 | Эмч | 8 | 12 | 12000 | 1152000 | 1 | 5 | 16000 | 80.000 | 1.232.000 |
| | **Дүн** | **8** | **12** | **12000** | **1.152.000** | **1** | **5** | **16000** | **80.000** | **1.232.000** |

### 3. Хоолны төсөв.

| Д/д | Зориулалт | Хооллох хүний тоо | Хэдэн удаа | Нийт хүн | Нэг өдрийн хоолны үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Цэрэг татлагын комисс | 13 | 2 | 26 | 8000 | 208.000 |
| 2 | Цэрэг хүргэж ирсэн офицеруудыг хооллох | 18 | 5 | 90 | 8000 | 720.000 |
| 3 | **Дүн** | **31** | **7** | **116** | **8000** | **928.000** |

### 4.Бусад зардал

| № | Материалын нэр | Нэг бүрийн үнэ | Тоо ширхэг | Нийт үнэ |
|---|---|---|---|---|
| 1. | Цэргийн алба хаах хэлбэрүүд /гарын авлага, тараах материал/ | 300 | 1000 | 300.000 |
| Нийт үнэ | | | | **300.000** |

**Цэрэг татлагын нийт зардал – 3.711.760**